



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ


Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ


2020 оны 3-р сар

МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 16,953 **-11%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс, 7,849 **-16.7%**, МХБ-В индекс 7,564 **-3.2%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.02.29	2020.03.31	Өөрчлөлт, %
DJIA (US)	25,409	21,917	-13.7%
S&P 500 (US)	2,954	2,584	-12.5%
Nikkei 225 (JP)	21,142	18,917	-10.5%
Hang Seng (HK)	26,129	23,603	-9.6%
DAX 30 (DE)	11,890	9,935	-16.4%
SMI (CH)	9,831	9,311	-5.2%

Валютын ханш

Валют	2019.02.29	2020.03.31	Өөрчлөлт, %
USD	2,762.71	2,777.74	0.5%
EUR	3,039.26	3,054.54	0.5%
JPY	25.37	25.62	0.9%
RUB	41.16	35.37	-14.0%
CNY	394.75	391.62	-0.7%
KRW	2.28	2.28	0.0%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	3.3	73%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,486.9	-9.4%
Бүртгэлтэй компани	198	198
Арилжаалагдсан хувьцаа	90	+18
Арилжаалагдсан өдөр	22	+5

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.02.29	2020.03.31	Өөрчлөлт, %
AMT	78.00	185.80	+138%
CHE	900.00	1,500.00	+66.6%
GTL	15,250.00	20,400.00	+33.7%
CHR	240.00	300.00	+25%
TEX	7500.00	9,345.00	+24.6%

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2019.02.29	2020.03.31	Өөрчлөлт, %
SUL	88,000.00	62,150.00	-29%
GOV	242.90	173.78	-28%
LEND	40.00	29.98	-25%
RMC	29.94	24.00	-19%
MIK	14,800.00	11,910	-19%

Зах зээлийн мэдээлэл

Хувьцаат компаниудын ногдол ашгийн шийдвэр

2020 оны 2-р сарын 20-ны байдлаар МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниудаас 95 хувьцаат компани шийдвэрээ биржид ирүүлсэн ба 29 хувьцаат компани ногдол ашиг тараахаар, 2 компани ХЭХ-аараа шийдвэрлэхээр, бусад хувьцаат компаниуд ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг дорх линкээр орж үзнэ үү.
http://mse.mn/uploads/images/copy_of_nogdol.xlsx1_1.pdf

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд энэ 3-р сард нийт 106,829 данс нээгдснээс 90,243 данс шинээр, 16,586 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 90,233 дотоодын иргэн, 1 гадаадын иргэн, 9 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

“Цэнхэр, ягаан” тасалбараар худалдан авсан хувьцааны мэдээллийг шалгах заавар

Иргэдийн нэр дээр бүртгэгдсэн аливаа үнэт цаас/хувьцаа, түүнд ногдох ногдол ашгийн мөнгө нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд /ҮЦТХТ/ бүртгэгдэн хадгалагддаг тул иргэд цэнхэр, ягаан тасалбартай холбоотой мэдээллийг брокероор дамжуулахгүйгээр шууд тус төвөөс авах боломжтой. ҮЦТХТ нь төрийн байгууллага бөгөөд Чингэлтэй дүүргийн байрны чанх урд талд байрладаг.

Цэнхэр, ягаан тасалбарыг 1990-ээд оны өмч хувьчлалаар иргэдэд тараасан. Их хувьчлалын цэнхэр тасалбар нь хувьцаат компанийн хувьцаа авах эрхийн бичиг байв. Иргэд цэнхэр тасалбараар хувьцаа авахдаа брокерийн пүүс дээр очиж, хувьчлагдсан улсын компаниудын хувьцаанаас сонгож захиалга өгөөд, ар талд нь тэмдэглэл хийлгэдэг байжээ. Харин бага хувьчлалын ягаан тасалбар гэдэг нь иргэд өөрсдөө захиран зарцуулахад зориулан олгосон, нэгж үнэ нь 1000 төгрөгний үнэтэй тасалбар байсан тул энэ талаарх мэдээлэл ҮЦТХТ-д байдаггүй. Тухайн үед зарим хүмүүс авсан тасалбараа гудамжинд зарж, зарим нь огт хэрэглэхгүй гэртээ дарж, эсхүл хэн нэгэн хүнд өгч үрэгдүүлсэн байдаг. Мөн, тэр үед хүн бүрт данс нээхгүйгээр нэг хүний нэр дээр данс нээж, гэр бүлийнхний нийт хувьцааг бүртгэж болдог байсан тул ихэвчлэн өрхийн тэргүүн эсхүл гэр бүлийнхээ асуудлыг хөөдөлдөж явсан хүний нэр дээр хувьцааны данс нээгдэж, хувьцааг бүртгэсэн байдаг.

Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчим

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 1-р сарын 29-ний өдрийн 29 дүгээр тогтоолын дагуу үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг 2020 оны 3-р сарын 31-ний өдрөөс эхлэн нэвтрүүлээ. Шинэ Т+2 горимтой холбоотой гарсан өөрчлөлтүүд:

- Таны өгсөн захиалгын хэлцэл биелснээс хойш 2 ажлын өдрийн дараа төлбөр тооцоо хийгдэж, үнэт цаасны өмчлөх эрх шилжинэ.
- Үнэт цаасны төлбөр тооцоог Арилжааны төлбөр тооцоо ХХК хийдэг байсныг больж, тус байгууллага Клирингийн төв болж, зөвхөн үнэт цаас болон мөнгөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөний тооцоолол буюу клирингийг хийж гүйцэтгэх, мөн төлбөрийн саатал болон дефолт гарсан нөхцөлд

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн. сая төг	Эзлэх %
AARD	493,111	742.5	21.9%
MDR	2,097,336	629.2	18.6%
INV	175,154	445.0	13.1%
MNP	570,740	349.2	10.3%
APU	471,945	273.2	8.0%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2019.02.28	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
AMT	0.2	2.9	+138.0%
CHE	57.1	38.4	+66.6%
GTL	24.6	8.3	+33.7%
CHR	0.171	0.42	+25.0%
TEX	10.8	2.6	+24.6%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2019.02.28	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
SUL	5.7	1.6	-29.3%
GOV	189.4	53.9	-28.4%
LEND	32.0	8.0	-25.0%
RMC	2.3	0.467	-19.8%
MIK	306.4	59.8	-19.5%

эрсдэлийг удирдах үүрэгтэй болсон.

- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх болсон.
- Үнэт цаасны компаниудыг санхүү, хүний нөөц, программ хангамжийн чадавх дээр нь тулгуурлан клирингийн гишүүнчлэлээр элсүүлсэн. Эдгээр гишүүнчлэлтэй үнэт цаасны компаниар дамжуулан хөрөнгө оруулагчид захиалга өгч буй дүнг 30 хүртэл бууруулсан дүнгээр барьцаа байршуулан, үнэт цаасны захиалга өгч арилжаанд оролцох нөхцөл бүрдсэн. Гэхдээ байршуулах барьцааг 30 хувь хүртэл бууруулах уу, 100 хувь хэвээр байлгах уу гэдгийг үнэт цаасны компаниуд тухайн харилцагчийн эрсдэлийг үнэлсний үндсэн дээр харилцагч тус бүрээр тогтоох юм.

Хар хорум пропертийс ХК-ийн арилжааг сэргээв

МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх болсон тул Хар хорум пропертийс ХК-ийн үнэт цаасны (MSE:AMT) бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан үнэт цаасны арилжааг 2020 оны 1-р сарын 2-ны өдрөөс эхлэн түр зогсоогоод байсныг 2020 оны 3-р сарын 13-ны өдрөөс эхлэн сэргээж, арилжааг нээхээр болов.

Та өөрөө гар утаснаасаа шууд арилжаа хийхийг хүсвэл манай “Цахим данс” системд бүртгүүлээрэй. Мөн гар утасны аппликэйшн татан авч, онлайн арилжаа хийж, дансаа хянах боломжтой.

“ЦАХИМ ДАНС” СИСТЕМ

<https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment

Available on the App Store

ANDROID APP ON Google play

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 3-р сарын эцэст 20.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.7 (3.5%) их наяд төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 789.4 (27.2%) тэрбум төгрөгөөр, валютын харилцах 587.3 (29.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 3-р сарын эцэст 847.8 тэрбум болж, өмнөх оны мөн үеэс 50.0 (5.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жилийн эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019.03	2020.03*
Мөнгө M2	19,699.6	20,390.3
Бага мөнгө M1	3,666.6	3,446.1
Төгрөгийн харилцах	3,058.0	2,875.4
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	608.6	570.7
Бараг мөнгө	16,032.9	16,944.2
Төгрөгийн хадгаламж	11,147.8	10,682.4
Валютын хадгаламж	2,896.8	3,686.2
Валютын харилцах	1,988.3	2,575.6
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	897.8	847.8

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3-р сарын эцэст 17.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 200.9 (1.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 315.4 (1.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 3-р сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 120.0 (11.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 236.6 (25.9%) тэрбум төгрөгөөр өсчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 3-р сарын эцэст 1.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 9.1 (0.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 32.3 (1.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зургаг 35. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн нийт хэмжээ 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 2.2 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 2.1 их наяд төгрөг болж нийт орлогын 93.2 хувийг эзэлж байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.



Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2020 оны эхний 2-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 429.8 сая ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 173.3 сая ам. доллараар өсчээ. Урсгал данс 439.7 сая ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 217.0 сая ам. доллар, анхдагч орлогын данс 192.8 сая ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Зургаг 43. Урсгал дансны алдагдал, сая америк доллараар



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 оны эхний улиралд нийт 121 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2.2 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 1.0 тэрбум ам. доллар, импорт 1.2 сая ам. долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 860.1 (28.1%) сая америк доллар, үүнээс экспорт 735.9 (41.5%) сая ам. доллараар, импорт 124.2 (9.7%) сая америк доллараар тус тус буурчээ.

Зургаг 44. Экспорт, импорт, тэнцэл, сая америк доллар




Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2019 оны эхний улиралд 485.9 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 611.7 сая америк доллараар буурч, 125.8 сая америк долларын алдагдалтай байна.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 3-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны эцсээс 2.9 хувь, өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өссөн байна.

Зургаг 45. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (мөнх оны мөн үеэс 100), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 3-р сард өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 10.5 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 20.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.3 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.0 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 4.5 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2020 Стандарт инвестмент ҮЦК